



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/86

Булган сум

**“Алтаргана 2024” наадам, “Шинэ хөгжлийн зам”
үйл ажиллагааны хөтөлбөрийг олон нийтэд
сурталчлахад хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II хуралдааны аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр, 2023 оны XIX хуралдааны Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай 2023 оны XIX/08 дугаар, 2023 оны XIX хуралдааны “Алтаргана 2024” наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хугацааг тогтоох тухай 2023 оны XIX/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн явц, гарсан үр дүн, “Алтаргана 2024” наадмыг зохион байгуулах бэлтгэл ажил, уралдаан тэмцээн, наадмын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах хэвлэл мэдээллийн хэрэгслийг хавсралтаар баталсугай.


2. Хавсралтад тусгагдсан 17 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т, хавсралтад тусгагдсан 125,000,000 (нэг зуун хорин таван сая) төгрөгийг “Алтаргана-2024” наадмын төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 22-ны өдрийн А.186 дугаар
захирамжийн хавсралт



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр	Үнийн дүн
1	2	3
1	MNB	30.000.000
2	Монголын мэдээ сонин	3.000.000
3	Сайхан монгол ТВ	20.000.000
4	Цахиур	7.000.000
5	Asuu.mn	5.000.000
6	Булганы мэдээ МОНЦАМЭ	5.000.000
7	Dardas.mn	5.000.000
8	Хөвсгөлийн өнгө http://khuvsguliinungu.mn/	5.000.000
9	“Иргэний сэтгүүл зүйн боловсрол” ТББ https://todaynews.mn/	5.000.000
10	“Сэтгүүлчдийн цахим сүлжээ” ТББ https://www.erdenetlife.mn/	5.000.000
11	“Номин макс” ХХК /Nomin TV/	5.000.000
12	Булган хангай	5.000.000
13	“Буйлхан ногоон хөгжил”	5.000.000
14	HELLO BULGAN	5.000.000
15	Ашин Булган	5.000.000
16	“Ган үзэгтэн” ХХК www.zarig.mn	5.000.000
17	www.inder.mn	5.000.000
	Нийт дүн	125.000.000